

# ХӨВСГӨЛ АЙМГИЙН ХӨТӨЧ НОМ



Photo by Bayar

# ХӨВСГӨЛ

## АЙМГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА МЭДЭЭЛЭЛ

Хөвсгөл аймаг нь БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1931 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн тогтоолоор анх байгуулагдсан.

Аймгийн төв: Мөрөн хот

Хэдэн сумтай: 23 сум, 1 тосгон

Нутаг дэвсгэрийн хэмжээ: 100,600 км<sup>2</sup>

Хүн ам: 134,318 (2020 он)

Угсаатан: Халх, дархад, хотгойд, урианхай

Малын тоо толгой: 6,037,300 (2021)

Утасны код: +976 (0) 138

Шуудангийн дугаар: 67000

ТХ-ийн улсын дугаар: ХӨ

Цахим хуудас: <https://khovsgol.gov.mn/>

Хөвсгөл аймаг Монгол улсын 6 дахь том дэвсгэр газартай аймаг. Үндсэндээ уулархаг. Уул, ус, ой, хөвч, тайга болсон нутгийг аялагч жуулчид үзээд «Монголын Швейцар» гэж нэрийдэх нь бий. Аймгийн нутаг дэвсгэр нь Хангайн уулархаг мужид оршдог. Уул нурууны гол хэсэг нь хангай нурууны салбар хэсэг Хөвсгөл Тагна, Соёны нуруу багтана. Дэлгэрхаан уулын ноён оргил нь далайн түвшнээс дээш 3190 метр өндөрт орших ба аймгийн нийт нутаг дэвсгэр нь далайн түвшнээс 1650-2050 метр өргөгдсөн. Хангайн нуруунаас эх авсан Идэр, Тэс, Бүгдгээн, Хөвсгөл нуурын баруун ба зүүн талын уулсаас эх авсан Дэлгэр мөрөн, Бэлтэс, Шарга, Шишгэд, Эг, Үүр, Уйлган зэрэг 400 гаруй гол мөрөн, горхи булагтай. Хөвсгөл аймагт 300 гаруй том, жижиг нуур байдаг. Эдгээр нууруудын дотроос цэнгэг тунгалагаараа дэлхийд тэргүүлдэг, талбайн хэмжээгээрээ Ази тивд аравдугаарт, Монгол оронд хоёрдугаарт, гүнээрээ Төв Азид хоёрдугаар ордог Хөвсгөл нуур байна. Тус аймагт анагаах чадлаараа улс даяар алдартай Булнай, Салбарын халуун рашаан, Торц, Дулаан бүлээн, Наранбумбат, Хоногцол, Бөөстөг, Гантигт зэрэг хүйтэн рашаан.



# МӨРӨН

ХОТЫН ТУХАЙ



Аймгийн төв Мөрөн хот улсын нийслэлээс баруун хойш 671 км зайтай. 1809 онд Дэлгэр мөрний эрэгт Мөрөнгийн Хүрээ бий болсноор Мөрөн хотын түүх эхэлдэг. 20-р зууны эхэн гэхэд тус хийд нь 1300 орчим ламтай том хийд байсан боловч 1937 онд сүйтгэгджээ. Данзадаржаа хийд гэдэг жижиг хэмжээний шинэ хийд 1990-ээд онд хотын баруун хэсэгт баригджээ.

Өрхийн тоо: 11,849 (2020)

Хүн амын тоо: 44,496 (2020)

Улаанбаатар хотоос алслагдсан зай: 671 км



ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
**АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ  
ЭРХЛЭГЧДИЙН**  
ХОЛБОО

Хөвсгөл аймгийн аялал жуулчлалын холбоо

Хөвсгөл аймагт үйл ажиллагаагаа явуулдаг аялал жуулчлалын 2 холбоо байдаг.

**ХӨВСГӨЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ ЭРХЛЭГЧДИЙН ХОЛБОО**

Бид Хөвсгөл аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, байгаль орчинд ээлтэй, эко орчинг бүрдүүлж, салбарын үйлчилгээний чанар, аюулгүй байдал, хариуцлагыг дээшлүүлэх зорилготойгоор мэдлэгт суурилсан хамтын ажиллагааг бэхжүүлж олон улсын жишигт нийцэхүйц үйлчилгээг нэвтрүүлэх алсын хараатай байгуулагдсан.

Байгуулагдсан огноо: 2013

Гишүүдийн тоо: 40

**ХӨВСГӨЛ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ ЗОЧЛОХ ҮЙЛЧИЛГЭЭ ТББ**

Тус холбоо нь тус аймагт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, хувь хүмүүсийг хариуцлагатай, тогтвортой аялал жуулчлал эрхлэх, орон нутгийн иргэдийн амьжиргаанд тус дэм болоход нэгдсэн зохион байгуулалттайгаар ажиллах зорилготой.

Байгуулагдсан огноо: 2019

Гишүүдийн тоо: 20

# ХӨВСГӨЛ АЙМГИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МАРШРУТУУД

## Алтан цагираг маршрут

*/Дархадын хотгорын чиглэл/*

**Чиглэл нь:**

Мөрөн хот – Уушигийн өвөр буган чулуу хөшөө – Мөнх хааны гэрэлт хөшөө – Өндөр Ухаагийн хөтөл – Бадрахын өврийн буган чулуу – Цагаан чулуутын даваа – Эмтийн буган чулуу – Уширын хүрхрээ – Өлийн Арван Гурван овоо – Мөнх мөс үзэсгэлэнт газар – Хоригийн хүрээний туурь – Хоригийн буган чулуу – Бошдог нуур – Хурганы нуур – Хөгийн гол – Боомын рашаан /үзэсгэлэнт нуурууд/ – Доод Цагаан нуур – Хотгорын ам – Тэнгэс гол – Хогоргын гол – Тарган нуур – Шар давааны буган чулуу – Цэцэгт нуур – Арсайн гол – Бэлтэсийн агуй – Ямаатын хавцал – Улаан толгойн буган чулуу – Хядагийн буган чулуу

## Хөх сувд цагираг маршрут

*/Хөвсгөл нуурын чиглэл/*

**Чиглэл нь:**

Мөрөн хот – Уушигийн Өвөр буган чулуу хөшөө – Ачит нуур – 50:100 төв – Хатгал тосгон – Жанхайн даваа – Жанхай эрэг

## Мөнгөн цагираг маршрут

*/Алунгоо чиглэл/*

**Чиглэл нь:**

Зүлэгт – Улаан хясаа – Дани толгой – Эгийн гол – Ёндонпунцаглан хийд (Даян дээрхийн хийд) – Даян дээрхийн агуй – Зуун салаа мод – Алунгоо хатны хөшөө – Булжихын голын буган хөшөө – Булнайн рашаан – Тэгтийн давааны хадны сүг зураг – Хатгал тосгон

## Хүрэл цагираг маршрут

*/Зүүн нуурын чиглэл/*

**Чиглэл нь:**

Ороохын даваа – Арын хүрээний дуган 108 шаттай сүм – Хөнжилийн рашаан – Дашинпилжээлин хийд – Салбартын рашаан – Идэрийн гол – Бүгсэйн хүрээний суварга – Дашгэндүнжамбалан хийд – Сэнжит хад – Хөх хөтлийн агуй – Овооны энгэрийн хүн чулуу – Тэсийн гол – Уйгарын хааны хөшөө – Жугнайн нуур – Ус хийсдэгийн хүрхрээ – Агарын рашаан – Агарын хүрээний туурь – Агарын гол – Өвөгдийн хуйн хурлын туурь – Хүнхэрийн гол – Намаржингийн даваа – Өндөр ухаагийн хөтөл даваа – Мөнх хааны гэрэлт хөшөө – Уушигийн өврийн буган чулуу – Мөрөн хот

# ҮЗМЭРҮҮД

## ХӨВСГӨЛ АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

### ХӨВСГӨЛ НУУР

Хөвсгөл нуур нь Монгол улсын хойд хэсэгт Хөвсгөл аймагт оршдог. Энэ нуур нь Монголын хамгийн их эзлэхүүнтэй, хамгийн гүн нуур юм. Хөвсгөл нуур нь дэлхийн арван долоон эртний нуурын нэг юм. 2 сая гаруй жилийн настай хэмээн тооцоолсон байдаг. Нийт усны эзлэхүүн 381 км<sup>3</sup> байдаг нь дэлхийн цэнгэг усны 0.4 хувьтай тэнцэнэ. Хөвсгөл нуурт 46 гол горхи цутгах бөгөөд ганцхан Эгийн гол эх авч урсан Сэлэнгэ мөрөнд цутгана. Явсаар нийт 1000 км зайг туулан Байгал нуурт цутгадаг. Энэ хоёр нуурын хоорондын шууд зай нь ердөө 200 км. Хөвсгөл нуурын байгалийн цогцолбор газар Сибирийн тайга, Төв Азийн хээр талын бүсийн шилжилтийн хэсэгт хамаарна. Хөвсгөл нуурын өмнөд, хойд эрэгт орших Хатгал, Турт гэсэн хоёр боомтын хооронд зун цагт усан тээвэр хийгддэг. Хөвсгөл нуурын эргэн тойрон фосфоритоор баялаг. Уг нуур нь Монгол улсын аялал жуулчлалын томоохон чиглэл юм.



# ҮЗМЭРҮҮД

## ХӨВСГӨЛ АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

### СОЁНЫ БҮС НУТАГ

Хөвсгөл аймгийн хамгийн өндөр уул болох Соёны нурууны оргил "Мөнх сарьдаг" уул юм. Соёны нуруу нь Монгол улсын баруун хойд хэсэг болон өвөр Сибирьт байдаг уулархаг бүс нутаг юм. Зүүн соён ба баруун соён гэсэн хоёр хэсгээс бүрдэнэ. Баруун соён нь Бүгд Найрамдах Тува Улсад, зүүн Соён нь Хөвсгөл аймагт оршдог. Хамгийн өндөр цэг нь Хөвсгөл аймагт байх "Мөнх сарьдаг" уул бөгөөд 3491 метр өндөр. Алтай Соёны экобүс нутаг нь Дэлхийн Байгаль Хамгаалах Сан (WWF)-гаас тодорхойлсон дэлхий дээрх зайлшгүй хамгаалбал зохих 200 экобүс нутгийн нэг юм.



*Photo by Bayar*

# ҮЗМЭРҮҮД

## ХӨВСГӨЛ АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

### **ДАЯН ДЭЭРХИЙН АГУЙ**

Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын төвөөс зүүн хойш 35 километр зайд Үүрийн голын баруун цутгалд орших Монгол орны хамгийн том агуйн нэг бөгөөд 2006 онд тусгай хамгаалалтанд авсан. Даян дээрхийн агуй нь ховор тогтоцтой, байгалийн үнэт үзмэр юм. Дотроо 10 гаруй өрөөтэй, зүг бүртээ олон ам хаалгатай, олон янзын рашаантай, нарийн шороон будагтай. “Эхийн умай” гэдэг эмэгтэй хүний савыг дүрсэлсэн амсартай. Агуйн ам нь Номхон уулын дунд орчим зүүн урагш хандсан том дөрвөлжин хаалга хэлбэртэй. Даян дээрхийн агуйн орчных нь байгаль маш үзэсгэлэнтэй. Цагаан суварга, Сэнжит хад зэрэг том жижиг олон агуйтай. Агуйнуудын орчимд олон тооны хиргисүүр, булш байдаг.





# ҮЗМЭРҮҮД

## ХӨВСГӨЛ АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

### УУШГИЙН ӨВРИЙН БУГАН ХӨШӨӨ

Хөвсгөл аймгийн төв Мөрөн хотоос баруун зүгт 18 км зайд Бүрэнтогтох сумын нутаг Улаан Уушиг уулын өвөрт буган хөшөө болон хиргисүүрийн тахилгын байгууламжийн томоохон цогцолбор орших бөгөөд нэг дор 30 орчим буган хөшөө бий. Эдгээр хөшөө нь хойноосоо урагш цуварсан байрлалтай ба тэдгээрийн эргэн тойронд битүү болон цагариган хэлбэрийн чулуун дарааст олон тахилгын байгууламжуудтай. Энэхүү дурсгал нь Евразийн буган чулуун хөшөөт цогцолбор дурсгалуудын хамгийн олон хөшөөтэй нь бөгөөд хиргисүүр, буган хөшөөний соёлыг тээгч эртний ард түмний судалгаанд онцгой байр суурийг эзэлдэг.



# ҮЗМЭРҮҮД

## ХӨВСГӨЛ АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

### **УЛААН ТОЛГОЙН БУГАН ХӨШӨӨ**

Мөрөн хотоос 35 км Эрхэл нуурын баруун талд Улаан толгой уулын бэлд таван ширхэг буган хөшөө, ойр орчимд нь нэлээн хэдэн 1-2 метр өндөр дөрвөлжин болон дугуй хиргисүүр бий. Энэхүү буган чулуун хөшөөний хоёр дахь нь 3.40 см өндөр, Монголын хамгийн өндөр буган чулуу гэдгээрээ алдартай. Дээд талд нар, 9ш ташуу бөөрөнхий нүх хонхойлгон цохисон буганы дүрс тод дүрслэгдсэний дээр ойролцоо орших 4 буган чулуунаасаа хэмжээ, хийц урлалаараа өвөрмөц онцлогтой.



# ҮЗМЭРҮҮД

## ХӨВСГӨЛ АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

### **ДАРХАДЫН 13 ОВОО**

Монголчуудын овог ястаны нэг Дархад түмний тахин шүтэх зан үйл нь овоотой салшгүй холбоотой юм. Овоо нь хүний оюун ухаан, танин мэдэхгүй, ухаарлын оролцоотойгоор бүтсэн хамгийн эртний туурвил хэмээн үздэг байна.

Дархад нутаг руу орох давааны оройд 13 овоо байдаг. Энэ 13 гэдэг нь дархадчуудын шүтдэг тоо бөгөөд хүний ертөнцөд оршиж байгаа орон зайнд 10 зүг, 3 цаг байдаг. Энэ хоёрын нийлбэр нь 13-ын тоог бий болгож байгаа ажээ. Дархадчуудын шүтлэг бол 10 зүг, 3 цагтаа даатгал өргөж байгаа хэрэг ажээ. Хүн байгалийн харилцан шүтэлцэлийг ойлгох, хайрлан хамгаалахын илэрхийлэл нь овоотой салшгүй холбоотойн нэг илрэл нь энэхүү овоод юм.



# ҮЗМЭРҮҮД


## ХӨВСГӨЛ АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

### ЦААТНЫ НУТАГ

Хөвсгөл аймгийн Улаан-Уул, Рэнчинлхүмбэ, Баянзүрх, Ханх зэрэг сумдуудад нутагладаг. Тайгад 4 улирлын турш цаа буга маллан нүүдэллэн амьдардаг Тува иргэдийг цаатан гэж нэрлэдэг. Тэдний аж төрөх гол арга бол цаагаа маллан, ан ав хийж амьдрах бөгөөд Бүрхээлэг, Жамс, Улаан тайгын их уулс, Шишгэдийн голын сав нутгаар аж төрөн амьдардаг. Цаатангуудыг Тувагаас нүүдэллэн ирж Хөвсгөлийн тайгад суурьшсан гэж түүхчид үздэг. Цаатангууд өөрийн гэсэн хэл, ёс заншил, шашин шүтлэг, аж төрөх өвөрмөц арга барилтай үндэсний цөөнх юм. Тэд уйгар хэлтэй. Тайгадаа бол өөр хоорондоо уйгараар ярьдаг. Бөөгийн шашин шүтнэ. Аж төрөх гол арга нь бол цаагаа маллан, түүнийхээ ашиг шимийг хүртэж ан гөрөө хийж амьдардаг. Өдгөө 400 гаруй хүн буюу 100 гаруй өрх цаатан айл өвөлдөө хасах 31-50 хүртэлх хүйтэн цаг уурын хүнд нөхцөлд амьдардаг. Цаатангуудын хувьд өөрсдийн бичмэл түүх гэж байхгүй, уламжлалт зан заншил нь алдагдаж байгаа гэж судлаачид үздэг. Эрт цагаас цаатан ард түмний амьдарч ирсэн сууц нь урц юм. Нууц товчоо болон Рашид Ад дины судрын чуулганд ан гөрөөгөөр амьдардаг эртний аймгууд холтсон бүрээстэй гэрт амьдардаг гэж дурдсан байдаг.



# БУСАД ҮЗМЭРҮҮД



© Ts. Bat-Erdene

## ХОРЬДОЛСАРЬДАГ УУЛ

Хөвсгөл нуурын баруун талаар орших их уул. Шохойн чулуунаас тогтсон, шовх шовх оргилтой ой хөвч, тагийн бүс бүхий сүртэй сайхан уул. Оргил нь 3200 орчим м хүрнэ. Энэ хавийн уулын зүүн хэсэг нь дархан газарт багтах бөгөөд энд нэн ховор ойн цаа буга болон сибирийн хандгай, аргал болон явлаг сар, усны цагаан сүүлт бүргэд зэрэг ховор амьтад жигүүртэн шувууд оршдог. Энэ хавь уулын тайга, ян сарьдагт нутгийг 1997 оноос 1886 ам км талбайг хамруулан дархан газар болгожээ.

## УШИРЫН ХҮРХРЭЭ

Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын нутаг дахь Хорьдол Сарьдагийн Их уулсын энгэр хэсгээс эх авч урагш 90 км урсаж Дэлгэрмөрөнд цутгадаг Бэлтэсийн голд байх хүрхрээ. Бэлтэс гол өндөр уулсын дундуур урсдаг бөгөөд Баянзүрх сумын нутгийн орчим өндөр ханан хадан эрэгтэй болж, зарим хэсэгтээ 10-20 метр өндөр болдог. Голын өргөн зарим хэсэгтээ 20-30 метр болж гүн цүнхээл хэсэгтээ дөрвөн метр хүрдэг аж. Баянзүрх сумын төвийн орчмоор урсахдаа дөрвөн метрийн өндөр хаднаас буудаг багавтар хүрхрээ үүсгэдэг бөгөөд үүнийг “Уширын хүрхрээ” гэж нэрлэдэг байна. Матар хад гэсэн дэргэдээс нь харвал хүн хийсэн баримал шиг яг л усанд сэлээд явж Матар шиг хад байдаг.

## ЦЭЦЭГТ НУУР

Ринченлхүмбэ сумын төвөөс чанх хойш 45 км орчим зайд Ходон голын хойд хөндийд цэнгэг устай жижигхэн нуур байдаг. Нуурын урт өргөн 0,5 км орчим бөгөөд нуурын ус эзлэх талбай 2,5 км юм. Нуурын ус нь тийм гүн биш эрэг орчим 1-1,5 метр юм. Энэ нуур гадагш дотогш урсгалгүй. Ойрын дулааралтаас усны түвшин багасаж байгаа. Нууранд бөлбөө хэмээх нэг зүйлийн цэцэг ургана. Эл цэцэг нуурын эрэг орчмын болон гүехэн хэсэгт ургадаг. Нуурын ёроолоос 0,8- 1,1 метр өндөр урган нуурын мандал дээр үзүүрийн цэцэгтэй хэсэг гарахад том ногоон навчууд наран мандахад дэлбээлж дотроос нь хурц тод өнгийн ягаан, цагаан цэцэг гарна. Үүнийг харахад нуурын усан мандалд том далбагар ногоон навч дэвсэж, дээр өнгийн цэцэг тавьсан юм шиг үнэхээр сэтгэл бахдам үзэсгэлэнтэй байдаг. Бөлбөө цэцэг ингэж өглөө бүр дэлбээгээ нээж орой бүр хумидаг. Байгаль дэлхийн энэ өвөрмөц сонин бүтээл гадаад дотоодын жуулчдын очих сонирхлыг татдаг юм.



# БУСАД ҮЗМЭРҮҮД

## САЛБАРТЫН ХАЛУУН РАШААН


Галт сумын Рашаант багийн Гүртийн нурууны ар бэлээс оргилон гарах халуун рашаан усыг Салбартын халуун усны рашаан гэнэ. Рашааныг 300-гаад жилийн тэртээгээс нутаг хошууны ардууд үе мөч, чийг бам, бөөр нуруу, саа зэрэг элдэв өвчин эмгэгийг илааршуулахад хэрэглэсээр иржээ. Нэг дороос шахам оргилох таван булгаас секундэд 6,1 литр рашаан ус ундарна. Рашаан нь 38-40 хэм халуунтай. Рашаан усны найрлага хими, физикийн шинж чанарыг судалж үзэхэд бага эрсдэлжилтэй, сульфатын хлор, натри кальцын ион зонхилсон, геохимийн ангижруулах процесст бүрэлдэн тогтсон азотлаг хүхэрт- устөрөгчийн сульфатнатрийн ионы бүлэгт хамаарагдах рашаан юм. Рашааны хийн хяналтанд хүхэрт устөрөгчийн хий давамгайлж байдгаас эмчилгээний чанараар өндөр юм. Рашааны найрлага, үзүүлэх үйлчилгээгээрээ Завханы Отгонтэнгэр, Булганы Сайхны Хулж, өөрийн аймгийн Булнайн рашаантай ижил, газрын гүний рашаан юм.

## УС ХИЙСДЭГИЙН ХҮРХРЭЭ


Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын нутагт Тэсийн голоос хойш оршино. Хүрхрээний нэр нь уг хүрхрээний онцлогыг тусгасан байдаг. Хүрхрээ нь үндсэн гурван шаталгаа мэт харагдах ба үндсэн хүрхрээ нь их эрчтэй ус цацран буухдаа тухайн өдрийн салхины хүчээс шалтгаалан ийш тийш шилжин, байнга буудаг газраасаа бага зэрэг зайтай бууна. Мөн хүрхрээнээс ус нилээд цацран, ойрхи зайд борооны ус мэт шүршдэг. Ийм онцлогыг нь нутгийн хүмүүс сайн ажиглаж, Ус хийсдэгийн хүрхрээ гэж нэрлэжээ. Хүрхрээний ойрхи нутагт Шаварын голын ан амьтан, жимс, ургамлаар нэн баян хөндий, Дэдэн Түмбэ, Хонгор Азарга, Алтан Хөл, Бухлагт зэрэг сүрлэг уулс, Тэсийн голын өргөн хөндий, Жугнай (лам нар Ринченжугнай гэнэ), Тунамал нуур, хүн чулуун ба бугын зурагт хөшөөнүүд, 1905 оны газар хөдлөлийн хагархай мэт үзэх сонирхох зүйлс их бий.

## БОШЛОЙ ХАД, БЭЛТЭСИЙН АГУЙ

Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын нутагт хүн авирахад бэрх Бошлой хад хэмээх өвөрмөц сонин тогтоцтой хадан уул орших бөгөөд түүний баруун доор Бэлтэсийн гол Дэлгэрмөрөн голтой нийлдэг бэлчир оршино. Бэл тийш урсах гэдэг үгийн хувирал Бэлтэсийн голын нэрийг бий болгожээ. Хадан уулс нь гайхамшигтай. Бошлой хад нь өнчин Бошлой хүүгийн хайр сэтгэлийн домгийг он жилүүдийн уртад хадгалан оршино. Ноёны охинд хайр сэтгэлтэй болсон Бошлойг мөнөөх бэрх хадны нэгэн агуйд хорьж орхиж. Бошлой өвлийн туршид бүргэдийн хоёр дэгдээхий тэжээн хоёр улирал дамнан гаршуулаад намар нь шувууддаа зүүгдэн нисч агуйгаас оргожээ. Бэр буусан хуримнаас хайрт бүсгүйгээ оргуулан хил давж, Тувагийн зүгт зугтан одсон гэдэг. Өвөрмөц тогтоцтой хадан уулсын дунд сонин жигтэй, заримдаа оньсого таавар мэт нууцлаг зүйл ч элбэг. Борооны дараа 555 гэсэн бичиг хадан дээр тодрон үзэгдэх бөгөөд мэдээж үүнийг хүний гараар сийлээгүй гэх. 400 гаруй хонь элбэг багтах агуй ч байдаг байна. Энэхүү байгалийн тогтоц бүхий нутагт том, жижиг агуй, нүхэн сэнжит хад гэх мэт олон өвөрмөц хэлбэр дүрсийг харж болно.



# АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГУУД



## ХӨВСГӨЛ ДАЛАЙ ОРЧМЫН БААЗУУД

*Photo by Bayar*



### ART88 RESORT

📍 Хөвсгөл аймгийн  
Хатгал тосгон

☎ 88598888  
98568888

🌐 [www.art88resort.com](http://www.art88resort.com)

📄 lounge.resistors.showroom  
50.6782° N, 100.2391° E



### TOILOGT CAMP

📍 Хөвсгөл аймгийн  
Хатгал тосгон

☎ 99092273  
99999802

🌐 [www.hovsgoltravel.com](http://www.hovsgoltravel.com)

📄 lounge.resistors.showroom  
50.65591,100.25368 E



### ASHIHAI RESORT

📍 Хөвсгөл аймгийн  
Хатгал тосгон

☎ 89010066  
99264484


🌐 [www.ashihai.mn](http://www.ashihai.mn)

📄 lounge.resistors.showroom  
50°29'53.5"N 100°09'52E

# ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГУУД



## МӨРӨН ХОТЫН ЗООГИЙН ГАЗРУУД



### ЖАРГАЛАН

Хөвсгөл аймгийн  
Мөрөн хот, 8 баг

77388080, 96389494

Монгол, Европ, Ази хоол, хүргэлт  
[www.facebook.com/jargalan-restaurant](http://www.facebook.com/jargalan-restaurant)

lounge.resistors.showroom  
46.2729° N, 102.7790° E



### 50, 100

Хөвсгөл аймгийн  
Мөрөн хот, 8 баг, 4 зам

70382000

Ази, Европ, Монгол хоол  
[www.50100.mn](http://www.50100.mn)

lounge.resistors.showroom  
46.2729° N, 102.7790° E



### ТИТАНИК

Хөвсгөл аймгийн  
Мөрөн хот, 3 баг

89993515, 70385555

Монгол, Солонгос  
[www.facebook.com/titanik](http://www.facebook.com/titanik)

lounge.resistors.showroom  
46.2729° N, 102.7790° E



# ЭВЭНТ БАЯР НААДМУУД

## ХӨХ СУВД МӨСНИЙ БАЯР

“Хөх сувд” мөсний баярыг Хөвсгөл нуураа хамгаалах, өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор анх 2000 оноос эхлэн жил бүрийн 3 дугаар сарын 2,3 нд зохион байгуулдаг. Мөсний баярын үеэр мөсөн хотхон байгуулж, Хаан их сарьдаг, Хатан далай ээждээ хүндэтгэл үзүүлж, хөтөлбөрийн дагуу уралдаан тэмцээнүүдийг зохион байгуулдаг.

**Хугацаа:**

Жил бүрийн 3 сарын 04 - 05  
**Зохион байгуулагдах газар:**

Хөвсгөл нуур, Хатгал тосгон,  
Доод модот булан

**Мөсний баярын Хөтөлбөр:**

Тахтай морин чарганы уралдаан, Тахтай хатирч морьдын уралдаан, Мөсөн дээрх шагайн харваа, Сурын харваа, Тэшүүрийн тэмцээн, Буухиа тэмцээн, Автомашин уран жолоодлого, Олс таталт, Мөсөн дээрх сумо, Сээр шалгах наадам, Мөс мөргөлдүүлэх тэмцээн, Мөсний хоккей, Аав, ээж, би гэр бүлийн тэмцээн, олон ястны ардын урлагийн тоглолт, үндэсний хувцасны загварын үзүүлбэр, галын наадам, бөөгийн үзүүлбэрүүд

Мэдээлэл авах утас: 99038770,  
80041337, 99888681



## ЦААТАН ФЕСТИВАЛЬ

Цаатан фестивалийг соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, уйгар иргэдийн өвөрмөц зан заншил, өв соёлыг таниулах, нутгийн иргэдийг дэмжих зорилгоор Далай тур жуулчны баазаас санаачлан 2006 оноос зохион байгуулж эхэлсэн. Жил бүрийн 7 дугаар сарын 6,7 нд “Жанхайн Цагаан эрэг”-т зохион байгуулдаг.

**Хугацаа:**

Жил бүрийн 7 сарын 07 - 08  
**Зохион байгуулагдах газар:**  
Хөвсгөл нуур, Жанхай цагаан эрэг

**Цаатан фестивалийн хөтөлбөр:**

Монгол үндэсний бэсрэг наадам, урлагийн тоглолт, Цааны уралдаан, Цаан поло, Галын наадам, Бөөгийн дуудлага зэрэг арга хэмжээнүүд зохион байгуулагдаж, аялагч жуулчид үзэж сонирхохоос гадны өөрсдөө оролцож авхаалж самбаагаа сорьдог.

Мэдээлэл авах утас: 88118548



# ЭВЭНТ БАЯР НААДМУУД

## САРЛАГ НААДАМ

**Сарлаг наадам** нь монгол сарлагийг сурталчилах, малчдын сарлаг маллах уламжлалт арга ухаан болон түүх соёлын өвийг олон нийтэд сэргээн таниулах, сарлагийн түүхий эд /сүү, мах, арьс шир, хөөвөр/-ийг ашиглан өрхийн орлогоо нэмэгдүүлэх болон аялал жуулчлалын бүсийн малчдыг дэмжих, урамшуулах зорилготой 2014 оноос эхлэн аймгийн Бэлчээр ашиглагчдын холбоо, Жинст Мөрөн компаниас санаачлан зохион байгуулж байгаа.

**Хугацаа:**

Жил бүрийн 7 сарын 20

**Зохион байгуулагдах газар:**

Алаг-Эрдэнэ сум

**Сарлаг наадмын хөтөлбөр:**

Сүлжмэл бүтээгдэхүүн болон сарлагийн сүү, сүүн бүтээгдэхүүн, гар урлалын бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа, Бөхийн барилдаан, Үндэсний сур харвалтын тэмцээн, Сарлаг бугуйлдах, булгиулах тэмцээн, Хамгийн их сүүтэй сарлагийн үнээг шалгаруулах, Сарлаг унасан сайхан хос шалгаруулах тэмцээн, урамшуулах үйл ажиллагаа явагддаг.

Мэдээлэл авах утас: 99994240,  
99002855



## ДАЯНДЭЭРХИЙН ШАГАЙН ТОЙРОМ НААДАМ

Үндэсний шагайн харвааг хөгжүүлэх, нутгийн иргэдийг дэмжих, аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг нэмэгдүүлэх зорилгоор МОН 9183"Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газрын орчны бүсийн иргэдийн амьжиргааг дэмжих, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх нэгдсэн төслийн санаачилснаар 2018 оноос эхлэн Цагаан-Үүр суманд жил бүрийн 6 дугаар сарын 29,30 нд зохион байгуулагдаж байна.

**Хугацаа:**

Жил бүрийн 7 сард

**Зохион байгуулагдах газар:**

Цагаан-Үүр сум



# АЛТАН ЦАГИРАГ АЯЛАЛЫН МАРШРУТ



## АЛТАН ЦАГИРАГ АЯЛАЛЫН МАРШРУТ



- БЦГ
- ДЦГ
- ДГ
- ✖ Морин аялал
- Сумын төв
- Өөр маршрут руу шилжих зам

- START Аялалын эхлэл
- Үзэх
- ✖ Морин аялал
- Зам
- ▲ Амрах газар

© Хөвсгөл аймгийн мастер төлөвлөгөө

### АЛТАН ЦАГИРАГ АЯЛАЛЫН МАРШРУТ ДАЙРАН ӨНГӨРӨХ ГАЗРУУД

- Залаатын даваа
- Рашаант сумын төв
- Тариатын даваа
- Сэлэнгэ мөрөн
- Тосонцэнгэл сумын төв
- Ачмаг нуур
- Мөрөн хот
- Уушигийн өвөр буган чулуу
- Мөнх Хааны гэрэлт хөшөө
- Өндөр Ухаагийн хөтөл
- Бадрахын Өвөрийн буган чулуу
- Цагаан чулуутын даваа
- Арбулаг сумын төв
- Эмтийн буган чулуу
- Баянзүрх сумын төв
- Уширын хүрхрээ
- Дэлгэр мөрөн
- Өлийн Арван Гурван овоо
- Мөнх Мөс үзэсгэлэнт газар
- Хоригийн хүрээний туурь
- Улаан Уул сумын төв
- Хоригийн буган чулуу
- Бошдог нуур
- Хурганы нуур
- Хөгийн гол
- Боомын рашаан /үзэсгэлэнт нуурууд/
- Доод цагаан нуур
- Цагааннуур сумын төв
- Хотгорын ам Байгалын үзэсгэлэнт газар
- Тэнгис гол
- Шишгэдийн гол
- Хогоргын гол
- Тарган нуур
- Шар давааны буган чулуу
- Цэцэгт нуур
- Арсайн гол
- Рэнчинлхүмбэ сумын төв
- Бэлтэсийн агуй
- Ямаатын хавцал үзэсгэлэнт газар
- Улаан Толгойн буган чулуу
- Хядагийн буган чулуу

Аялалын маршрут  
“Сүсэг бишрэлийн цогцолбор”  
Аялалын нийт км: 1253 км  
/аялагч нэмэлт 200 км  
тооцон шатахуунаа авах/

## АЛТАН ЦАГИРАГ - ДАРХАДЫН ХОТГОР -



### АЯЛЛЫН ОНЦЛОГ

Саяны эко системийн бүс нутаг, цаатан зон, бөө мөргөлийн голомт нутаг өөр хаана ч байхгүй байгалийн үзэсгэлэнт тогтоц Улаан тайга, Тэнгис Шишгэдийн хотгор Цаатан, Дархад, Урианхай, Тува олон үндэсний соёлын өлгий, Ердийн хөсөг, мориор аялна. Жилийн 4 улиралын турш аяллын бүтээгдэхүүнүүдээс сонгон аялах боломжтой.



### БАЙРЛАХ ХЭРЭГСЭЛ

Урцан отог  
Гэр  
Майхна засаад байрлах боломжтой отогууд



### БҮС НУТАГТ ХӨГЖҮҮЛЭХ АЯЛАЛ

Бөө мөргөлийн аялал, Морин аялал, Фото зургийн аялал, Гол мөрөн нуурын аялал, Байгалийн өвөрмөц тогтцот газраар аялах аялал, Рашааны аялал, Түүх соёлын дурсгал газраар аялах аялал, Цэцэг ажиглах аялал, Цаатан, Дархад зоны аж амьдралтай танилцах аялал, Завин аялал, Явган аялал, Ойн аялал



### ЗОНХИЛОХ СОЁЛ

Дархад, Цаатан зоны аж амьдрал, ахуй соёлтой танилцана.



### НЭРИЙН ХООЛ

Байгалийн гаралтай ургамал, борцтой эко хоол  
Дархад цай,  
Дархад архи

## АЛТАН ЦАГИРАГ (ДАРХАДЫН ХОТГОР)

### АЯЛЛЫН БҮТЭЭГДЭХҮҮН

Үзэсгэлэнт Шишгэдийн хотгор, гол мөрөн, нуурын орчим морин аялал

Фото зургийн аялал, байгалийн өвөрмөц тогтоц, ан амьтан, цэцэг, ургамал, гол мөрөн нуур, шувуу, цаатан зоны аж амьдрал, цаа маллагааны уламжлал, түүх соёлын зураг авах, гоо зүйн таашаал авах

Байгаль гоо зүй, эрүүл мэнд, танин мэдэхүйн аялал

Тусгай сонирхлын аялал: Фото зургийн аялал, завин аялал, спорт загас барих, морин аялал, ховор амьтан, ургамал, цэцэг ажиглах аялал, байгалийн зураг авах

Бөө мөргөлийн аялал  
Рашаан сувиллын аялал  
Цаатны амьдралаар амьдарч, ахуй соёлтой танилцах аялал

# МӨНГӨН ЦАГИРАГ АЯЛАЛЫН МАРШРУТ



## МӨНГӨН ЦАГИРАГ АЯЛАЛЫН МАРШРУТ

- МӨНГӨН ЦАГИРАГ АЯЛАЛЫН МАРШРУТ  
ДАЙРАН ӨНГӨРӨХ ГАЗРУУД**
- Зүлэгт
  - Улаан хясаа үзэсгэлэнт газар
  - Дани толгой
  - Эгийн гол
  - Эрдэнэбулган сумын төв
  - Эндонпунцаглин хийд (Даян дээрхийн хийд)
  - Даян Дээрхийн агуй
  - Зуун Салаа мод /Байгалын үзэсгэлэнт газар/
  - Цагаан-Үүр сумын төв
  - Чандмань-Өндөр сумын төв
  - Алунгоо хатны хөшөө
  - Булжихын голын буган хөшөө
  - Булнайн рашаан
  - Тэгтийн давааны хадны сүг зураг
  - Хатгал тосгон

Алалын маршрут  
"Алунгоо сүсэг бишрэлийн цогцолбор"  
Аялалын нийт км: 518 км  
/аялагч нэмэлт 150 км  
тооцон шатахуунаа авах/



## МӨНГӨН ЦАГИРАГ - АЛУНГОО -

**АЯЛЛЫН  
ОНЦЛОГ**

Монголын эртний язгуурны түүх ба хүний гар үл хур сон байгаль экологийн аялал зохиолсон маршрут Алтан ургийн дэд Дэх Чингис хааны язгуурны 11 дэх үеийн дээд өвөг Алунгоо хатны судлалын долдорт түүх, соёл, монгол хатны төв Даян-дээрхийн хийд, агуйн аялал Уулган, Эг, Дээрхийн рашаан уст голууд Хөвсгөлийн шигүү тайга

**БАЙРЛАХ ХЭРЭГСЭЛ**

Голцогцолбор нь "Бор югон малгайн хэлбэртэй гэр тэрэг" Гэр тэрэг Майхнаа засаад байрлах боломжтой отогууд

**ЗОНХИЛОХ СОЁЛ**

Буриад үндэстний аж амьдрал, ахуй соёлтой танилцана.

**ТУСГАЙ  
СОНИРХОЛЫН АЯЛАЛ**

Хүдэр, зэрлэг гахай, хүрэн бааргай зэрэг зэрлэг амьтан судлал, ажиглалт

**НЭРИЙН ХООЛ**

Барбекью, Ангын мах Улаан дарс

**МӨНГӨН ЦАГИРАГ (АЛУНГОО)**

**БҮС НУТАГТ ХӨГЖҮҮЛЭХ АЯЛАЛ**

Морин аялал, Фото зургийн аялал, Гол мөрөн нуурын аялал  
Байгалийн өвөрмөц тогтоцт газраар аялах, Рашааны аялал, Түүхийн дурсгалт газрын аялал, Цэцэг ажиглах аялал, Буриад зоны аж амьдралтай танилцах аялал, Завин аялал, Явган аялал, Ойн аялал

**АЯЛЛЫН БҮТЭЭГДЭХҮҮН**

Монгол хатдын суу ухааныг түгээн дэлгэрүүлэх хойч үе хүүхэд залуучуудыг хүмүүжүүлэх, байгалийн аялал

Даян Дээрхийн аялал, Эр хүний хийморь, сүсэг бишрэлийн аялалыг эко аялалтай хослуулсан Тусгай сонирхлын аялал: Фото зургийн аялал, завин аялал, спорт загас барих, морин аялал, ховор амьтан, ургамал, цэцэг ажиглах аялал, байгалийн зураг авах

© Хөвсгөл аймгийн мастер төлөөлөгчөө

# ХҮРЭЛ ЦАГИРАГ АЯЛАЛЫН МАРШРУТ



- ХҮРЭЛ ЦАГИРАГ-АЯЛАЛЫН МАРШРУТ ДАЙРАН ӨНГӨРӨХ ГАЗРУУД**
- Ороохын даваа
  - Арын хүрээний дуган
  - 108 шаттай сүм
  - Жаргалант сумын төв
  - Хөнжилийн рашаан, Дашинпилжээлин хийд
  - Галт сумын төв
  - Салбартын Рашаан
  - Идэрийн гол
  - Шинэ-Идэр сумын төв
  - Бүгсэйн хүрээний суварга
  - Дашгэндунжамбалын хийд
  - Сэмжит хад Байгалийн үзэсгэлэнт газар
  - Бүрэнтогтох сумын төв
  - Хөх Хөтөлийн агуй
  - Цагаан-Уул сумын төв
  - Овооны Энгэрийн хүн чулуу
  - Цэцэрлэг сумын төв
  - Тэсийн гол
  - Уйгарын Хааны хөшөө
  - Жугнайн нуур
  - Ус хийсдэгийн хүрхрээ
  - Агарын рашаан
  - Агарын хүрээний туурь
  - Агарын гол
  - Өвөгдийн Хуйн хурлын туурь
  - Хүнхэрийн гол
  - Намаржингийн даваа
  - Өндөр Ухаагийн хөтөл даваа
  - Мөнх Хааны Гэрэлт хөшөө
  - Уушигийн Өвөрийн буган хөшөө
  - Мөрөн хот

Аялалын маршрут  
 “Монголын нүүдэлчдийн  
 зан үйл соёлын цогцолбор”  
 Аялалын нийт урт : 1105 км  
 /аялагч нэмэлт 200 км  
 тооцон шатахуунаа авах/

© Хөвсгөл аймгийн мастер төлөвлөгөө

## ХҮРЭЛ ЦАГИРАГ - ЗҮҮН НУУР -

**АЯЛЛЫН ОНЦЛОГ**  
 Нутгийн зон олны аж амьдралыг дэмжих, мал маллагааны түүхэн уламжлалыг сурталчилах, байгалийн сайханд амрах эко цогцолбор Эртний буган чулуу, булш бунхан судлал Жалханз хутагт Содномын Дамдинбазар, Өндөр Гонгор, Гэлэнхүү алдартнуудын өлгий Архангай аймаг Хорго, Тэрхийн цагаан нуур, Завхан, Увс аймгаас зүүн чиглэлийн замтай ойрхон.

**БАЙРЛАХ ХЭРЭГСЭЛ**  
 Монгол гэр Майхнаа засаад байрлах боломжтой отогууд

**ЗОНХИЛОХ СОЁЛ**  
 Хотгойд үндэстний аж амьдрал, ахуй соёлтой танилцана.

**НЭРИЙН ХООЛ**  
 Монгол үндэстний бүх төрлийн хоол Монгол шимийн архи

**ТУСГАЙ**  
 Халуун рашаан Тусгай сонирхлын спорт загас барих, цэцэг ажиглах аялал, Буган чулуу, Дөрвөлжин булш, Мөнх хааны Эрчин хотын туурь судлалын аялал

**СОНИРХОЛЫН АЯЛАЛ**  
 сувиллын аялал аялал: Фото зургийн аялал, завин аялал, морин аялал, ховор амьтан, ургамал, байгалийн зураг авах

- ### ХҮРЭЛ ЦАГИРАГ (ЗҮҮН НУУР)
- БҮС НУТАГТ ХӨГЖҮҮЛЭХ АЯЛАЛ**
- Морин аялал, Фото зургийн аялал, Гол мөрөн нуурын аялал
  - Цэцэг ажиглах аялал, Байгалийн өвөрмөц тогтоцот газраар аялах аялал
  - Рашааны аялал, Түүх соёл, байгалийн дурсгалт газраар аялах аялал
  - Завин аялал, Явган аялал, Ойн аялал, Шашны аялал

# ЗЭС ЦАГИРАГ АЯЛАЛЫН МАРШРУТ



## ЗЭС ЦАГИРАГ АЯЛАЛЫН МАРШРУТ

### ЗЭС ЦАГИРАГ АЯЛАЛЫН МАРШРУТ ДАЙРАН ӨНГӨРӨХ ГАЗРУУД

- Рашаант сум ( Дашравжаалин хийд)
- Рашаан сумын төв
- Тариатын даваа
- Сэлэнгэ мөрөн
- Олон голын бэлчир
- Тосонцэнгэл сумын төв
- Ачмаг нуур
- Мөрөн хот

Аялалын маршрут  
“Хөвсгөл аймгийн жуулчин  
угтах үдэх төвийн аяллын маршрут”  
Аялалын нийт урт : 236 км

- БЦГ
- ДЦГ
- ДГ
- ✦ Морин аялал
- Сумын төв
- Өөр маршрут руу шилжих зам

- START Аялалын эхлэл
- 📍 Үзэх
- ✦ Морин аялал
- Зам
- ▲ Амрах газар

## ЗЭС ЦАГИРАГ - ОЛОН ГОЛЫН БЭЛЧИР -

**АЯЛЛЫН ОНЦЛОГ**  
Сэлэнгэ мөрөн, Идэр, Чулуутын бэлчирт түшиглэсэн эко аялал Буддын шашны хамгийн олон хийдийн туурь, үзмэр бүхий аяллын маршрут Цогтын цагаан, Чин толгойн хэрэм үзэх боломжтой. Дугуй засвар, шатахуун түгээгүүр, дэн буудал бүхий аяллын иж бүрэн үйлчилгээ нэг дор.

**БАЙРЛАХ ХЭРЭГСЭЛ**  
Олон улсын стандарт шаардлага хангасан Inn, Tavern – Орчин үеийн 00, ая тух. Майхнаа засаад байрлах боломжтой отогууд

**БҮС НУТАГТ ХӨГЖҮҮЛЭХ АЯЛАЛ**  
Морин аялал, Фото зургийн аялал, Гол мөрөн нуурын аялал, Цэцэг ажиглах аялал, Байгалийн өвөрмөц тогтоцот газраар аялах аялал, Рашааны аялал, Түүх соёл, байгалийн дурсгалт газраар аялах аялал, Завин аялал, Явган аялал, Ойн аялал, Шашны аялал

**ТУСГАЙ СОНИРХОЛЫН АЯЛАЛ**  
Загас бариад буцаан тавих спорт загас агнуур : Сэлэнгэ мөрөн нь 26 зүйлийн загастай : цурхай, зэвэг, алгана, булуу цагаан, хадран, улаан нүдэн, гутаарь г.м Загас бариад буцаан тавих : үнэт загас болох сибирь хилэм, тул, омуль г.м. Сэлэнгэ мөрөн нь хилэм загасны гол нүүдэллэдэг, түрсээ шахдаг газар

**НЭРИЙН ХООЛ**  
Олон үндэстний хоол  
Бүх төрлийн идээ, ундаа

## ЗЭС ЦАГИРАГ (ОЛОН ГОЛЫН БЭЛЧИР)

- АЯЛЛЫН БҮТЭЭГДЭХҮҮН**
- Сэлэнгэ мөрний завин аялал
  - Хангай нуруу тойрсон морин аялал
  - Тусгай сонирхлын аялал: Фото зургийн аялал, завин аялал спорт загас агнуур, морин аялал, ховор амьтан, ургамал цэцэг ажиглах аялал, байгалийн зураг авах

© Хөвсгөл аймгийн жэвсгөл төлөөлөгчөө